



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 19 өдөр

Дугаар A/31

Хэрлэн сум

Хүүхдийн эрхийн хууль зүйн
хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, Хөдөлмөр нийгмийн хамгаалал, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны A/190, A/280 дугаар тушаалаар батлагдсан Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмын 1.3, 3.3, 3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрх зүйн зохих хамгаалалт шаардлагатай хүүхдэд үйлчилгээ үзүүлэх зорилготой хүүхдийн эрхийн хууль зүйн хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Хорооны дарга: Аймгийн Засаг даргын орлогч

Хорооны гишүүд: Аймгийн Шүүхийн Тамгын газрын дарга

Аймгийн Проурорын газрын Ерөнхий прокурор

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Цагдаагийн газрын дарга

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга

Боловсролын газрын дарга

Эрүүл мэндийн газрын дарга

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга

Аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөлийн дарга

Дэлхийн зөн олон улсын байгууллагын Бор-Өндөр-2 хөгжлийн хөтөлбөрийн багийн ахлагч

Хүний эрхийн Үндэсний комиссын орон нутаг дахь ажилтан

Аймгийн хүүхдийн элч

Хорооны нарийн бичиг

бөгөөд ажлын

албаны дарга:

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга

231010102

2.

2. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг холбогдох журмын дагуу зохион байгуулж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал болон Хүүхдийн төлөө зөвлөлд хагас, бүтэн жил тутам ажлаа тайлагнахыг Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо (Л.Батсайхан)-д үүрэг болгосугай.

3. Бор-Өндөр суманд хүүхдийн эрхийн хууль зүйн хороог байгуулж, зохих журмын дагуу ажиллуулахыг Бор-Өндөр сумын Засаг дарга (Чинбат)-д даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны А/189 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ

